

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Могод сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/50/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
БУА	Булган аймаг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

1. Аудитын санал дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 85
танай _____ ны № _____ т

МОГОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Х.МӨНХ-АЛТАЙ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Могод сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Могод сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020141

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4foot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,317,770.32	64,060,544.52
33	АВЛАГА	5,365,464.00	4,798,838.20
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,365,464.00	-
335	Бусад авлага	-	4,798,838.20
3351	Байгууллагаас авах авлага	-	4,798,838.20
35	БАРАА МАТЕРИАЛ	52,952,306.32	59,261,706.32
354	Хангамжийн материал	51,689,106.32	57,936,506.32
35410	Бичиг хэргийн материал	652,375.00	1,541,475.00
35420	Аж ахуйн материал	10,785,821.40	15,292,121.40
35470	Бусад хангамжийн материал	40,250,909.92	41,102,909.92
35600	Мал амьтад	1,263,200.00	1,325,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,719,658,501.42	1,576,010,299.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,719,658,501.42	1,576,010,299.07
392	Биет хөрөнгө	1,693,324,501.42	1,547,926,299.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,996,248,398.10	1,923,216,398.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(540,943,539.68)	(585,236,006.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	164,640,000.00	164,640,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(90,762,517.68)	(113,259,184.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	146,093,415.85	136,271,966.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,423,021.52)	(46,167,518.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,805,849.17	74,682,830.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,869,086.04)	(26,555,629.07)
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,537,339.14	36,537,339.14
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,002,335.92)	(16,203,896.28)
393	Биет бус хөрөнгө	26,334,000.00	28,084,000.00
39301	Програм хангамж	300,000.00	2,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(350,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	26,334,000.00	26,334,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,777,976,271.74	1,640,070,843.59
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,777,976,271.74	1,640,070,843.59
51	Засгийн газрын хувь оролцоо	1,777,976,271.74	1,640,070,843.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	258,031,445.82	258,031,445.82
51101	Өмч: - төрийн	258,031,445.82	258,031,445.82
512	Хуримтлагдсан үр дүн	1,370,045,240.07	1,232,139,811.92
51210	Өмнөх үеийн үр дүн	1,370,045,240.07	1,370,045,240.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	(137,905,428.15)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	149,899,585.85	149,899,585.85

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,777,976,271.74	1,640,070,843.59
----------	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	434,049,841.00	434,550,438.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,068,570.00	4,046,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,068,570.00	3,781,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,068,570.00	3,781,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	580,500.00	2,991,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	488,070.00	790,500.00
122	Тусламжийн орлого	-	265,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	265,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	432,981,271.00	430,503,938.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,821,871.00	28,288,838.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,384,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	10,116,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,550,000.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,672,871.00	11,788,038.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,599,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	380,159,400.00	402,215,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380,159,400.00	402,215,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	489,119,424.22	563,261,671.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,119,424.22	563,261,671.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,554,301.57	539,147,707.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,271,584.75	215,738,012.07
210101	Үндсэн цалин	159,696,445.03	163,367,332.86
210102	Нэмэгдэл	53,010,850.42	49,538,189.21
210105	Гэрээт ажлын хөлс	3,564,289.30	2,832,490.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,099,500.60	27,672,182.94
210201	Тэтгэврийн даатгал	18,563,845.69	19,375,574.22

210202	Тэтгэмжийн даатгал	2,179,931.75	2,158,479.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,737,223.18	1,723,423.14
210204	Ажилгүйдлийн даатгал	419,645.66	402,258.16
210205	Эрүүл мэндийн даатгал	4,198,854.32	4,012,448.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,305,653.00	28,447,712.00
210301	Гэрэл, цахилгаан	4,905,002.00	3,364,191.00
210302	Түлш, халаалт	24,601,721.00	24,601,721.00
210303	Цэвэр, бохир ус	798,930.00	481,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,726,665.40	23,626,690.00
210401	Бичиг хэрэг	3,495,460.00	2,358,650.00
210402	Тээвэр, шатахуун	7,325,120.00	14,236,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,605,460.00	1,303,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,256,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	817,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,300,625.40	3,653,200.00
2105	Нормативт зардал	1,655,002.00	1,456,800.00
210502	Хоол, хүнс	1,655,002.00	1,156,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,428,540.00	4,823,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	694,540.00	2,811,500.00
210602	Тавилга	387,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	8,000.00
210604	Урсгал засвар	1,347,000.00	2,003,950.00
2107	Томилолт, зочны зардал	1,841,000.00	3,028,000.00
210702	Дотоод албан томилолт	1,841,000.00	3,028,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,322,676.00	13,774,787.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,757,286.00	11,374,838.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	249,750.00	182,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	299,000.00	292,509.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	582,640.00	1,836,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,903,679.82	220,580,073.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,768,445.00	41,290,065.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	94,000.00	160,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	72,041,234.82	179,129,607.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,565,122.65	24,113,963.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,450,000.00	1,551,597.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,000,000.00	551,597.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00	1,000,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,115,122.65	22,562,366.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,115,122.65	22,562,366.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(55,069,583.22)	(128,711,233.27)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	304,000.00	406,200.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	304,000.00	406,200.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	315,000.00	9,600,394.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	315,000.00	9,600,394.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,000.00)	(9,194,194.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(55,080,583.22)	(137,905,428.15)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	258,031,445.82	149,899,585.85	1,370,045,240.07	1,777,976,271.74
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(137,905,428.15)	(137,905,428.15)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,031,445.82	149,899,585.85	1,232,139,811.92	1,640,070,843.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	433,561,771.00	438,860,402.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	580,500.00	2,991,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	580,500.00	2,991,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	580,500.00	2,991,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	580,500.00	2,991,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	432,981,271.00	435,869,402.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,821,871.00	33,654,302.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,384,000.00

131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	10,116,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,550,000.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,672,871.00	17,153,502.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,599,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	380,159,400.00	402,215,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380,159,400.00	402,215,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	422,648,996.00	394,122,802.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,648,996.00	394,122,802.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,718,409.35	365,209,999.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,271,584.75	215,738,012.07
210101	Үндсэн цалин	159,696,445.03	163,367,332.86
210102	Нэмэгдэл	53,010,850.42	49,538,189.21
210105	Гэрээт ажлын хөлс	3,564,289.30	2,832,490.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,099,500.60	27,672,182.94
210201	Тэтгэврийн даатгал	18,563,845.69	19,375,574.22
210202	Тэтгэмжийн даатгал	2,179,931.75	2,158,479.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,737,223.18	1,723,423.14
210204	Ажилгүйдлийн даатгал	419,645.66	402,258.16
210205	Эрүүл мэндийн даатгал	4,198,854.32	4,012,448.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,305,653.00	28,447,712.00
210301	Гэрэл, цахилгаан	4,905,002.00	3,364,191.00
210302	Түлш, халаалт	24,601,721.00	24,601,721.00
210303	Цэвэр, бохир ус	798,930.00	481,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,156,590.00	15,894,590.00
210401	Бичиг хэрэг	2,226,010.00	2,306,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,325,120.00	8,546,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,605,460.00	1,303,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,251,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	841,600.00
2105	Нормативт зардал	990,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	990,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,614,200.00	15,814,700.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	649,000.00	2,046,000.00
210602	Тавилга	1,818,000.00	-
210604	Урсгал засвар	2,147,200.00	13,768,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,841,000.00	3,028,000.00
210702	Дотоод албан томилолт	1,841,000.00	3,028,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,994,436.00	13,774,787.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,429,046.00	11,374,838.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	249,750.00	182,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	299,000.00	292,509.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	582,640.00	1,836,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,445,445.00	44,885,215.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,351,445.00	44,664,815.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	94,000.00	220,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,930,586.65	24,113,963.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,450,000.00	1,551,597.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,000,000.00	551,597.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,115,122.65	22,562,366.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,115,122.65	22,562,366.99
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,365,464.00	4,798,838.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,365,464.00	4,798,838.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,912,775.00	44,737,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,912,775.00	44,737,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,912,775.00	44,737,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,912,775.00	44,737,600.00
222001	Тоног төхөөрөмж	2,500,000.00	9,664,000.00
223001	Бусад хөрөнгө	8,412,775.00	35,073,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,912,775.00)	(44,737,600.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	399,034,100.00	382,643,733.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,034,100.00	341,890,933.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,474,100.00	340,339,336.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,401,200.00	215,738,012.07
210101	Үндсэн цалин	167,350,800.00	163,367,332.86
210102	Нэмэгдэл	52,161,500.00	49,538,189.21
210105	Гэрээт ажлын хөлс	7,888,900.00	2,832,490.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,910,900.00	27,672,182.94
210201	Тэтгэврийн даатгал	19,952,500.00	19,375,574.22
210202	Тэтгэмжийн даатгал	2,239,600.00	2,158,479.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,791,700.00	1,723,423.14
210204	Ажилгүйдлийн даатгал	447,900.00	402,258.16
210205	Эрүүл мэндийн даатгал	4,479,200.00	4,012,448.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,756,700.00	28,447,712.00
210301	Гэрэл, цахилгаан	3,672,700.00	3,364,191.00
210302	Түлш, халаалт	24,602,000.00	24,601,721.00
210303	Цэвэр, бохир ус	482,000.00	481,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,679,100.00	15,894,590.00
210401	Бичиг хэрэг	2,579,200.00	2,306,450.00
210402	Тээвэр, шатахуун	9,474,300.00	8,546,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,638,800.00	1,303,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,251,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,486,800.00	1,486,800.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,899,600.00	15,814,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,921,400.00	2,046,000.00
210602	Тавилга	25,203,200.00	-
210604	Урсгал засвар	13,775,000.00	13,768,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,243,100.00	3,028,000.00
210702	Дотоод албан томилолт	3,243,100.00	3,028,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,833,500.00	2,399,949.00
210803	Даатгалын үйлчилгээ	284,400.00	182,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	296,000.00	292,509.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	-
210807	Газрын төлбөр	2,043,100.00	1,836,890.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,249,400.00	30,744,190.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,650,000.00	30,523,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	220,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,560,000.00	1,551,597.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,560,000.00	1,551,597.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	560,000.00	551,597.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	40,752,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	40,752,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	9,664,000.00
223001	Бусад хөрөнгө	-	31,088,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	358,162,000.00	405,206,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	396,193,100.00	402,215,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	396,193,100.00	402,215,100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,841,000.00	2,991,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,841,000.00	2,991,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	33,654,302.00	(33,654,302.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	30,314,702.00	(30,314,702.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	30,314,702.00	(30,314,702.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	11,374,838.00	(11,374,838.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	11,374,838.00	(11,374,838.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	18,939,864.00	(18,939,864.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	18,939,864.00	(18,939,864.00)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,339,600.00	(3,339,600.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,339,600.00	(3,339,600.00)
223001	Бусад хөрөнгө	-	3,339,600.00	(3,339,600.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	33,654,302.00	(33,654,302.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	33,654,302.00	(33,654,302.00)

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,384,000.00	(1,384,000.00)
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	10,116,800.00	(10,116,800.00)
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00	(5,000,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,153,502.00	(17,153,502.00)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Могод сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн толилуулга, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Могод сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/49 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон нутгийн түвшинд Төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, төрийн үйлчилгээний ил тод нээлттэй шуурхай байдлыг хангаж, бүх нийтийн оролцоо, төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгон, төрийн бодлогын залгамж, чанар, салбар хоорондын уялдааг сайжруулан, төрийн байгууллагуулын удирдлагын манлайлалыг дээшлүүлэх замаар хариуцлагатай замаар хариуцлагатай Зөв засаглалыг бүрлүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могод сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 489,119.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,891.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,423.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авллага	5,365.50	4,798.80	(566.70)
Бараа материал	52,952.30	59,261.70	6,309.40
Үндсэн хөрөнгө	1,719,658.50	1,576,010.30	(143,648.20)

Нийт хөрөнгө	1,777,976.30	1,640,070.80	(137,905.50)
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,777,976.30	1,640,070.80	(137,905.50)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,777,976.30	1,640,070.80	(137,905.50)

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 402,215.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 33,654.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 2,991.0 мянган төгрөгийг бүрдүүлэн нийт 438,869.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 413,307.0 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 22,562.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Авлага тайлант хугацаанд 4,798.8 мянган төгрөг болж, 566.7 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн дансны өмнөх оны авлага төлөгдсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,261.7 мянган төгрөг болж 6,309.4 мянган төгрөгөөр өссөн нь малын нас дэмжилтээс орлого, зуух, тусгай багаж, ковид-19 холбоотой ариутгалын бодис, тул далбаа, төрийн сүлд, уртасгагч, хогийн шүүр, паднуус, ус буцалгагч, сэлбэг хэрэгсэл, гэрэл, сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материалын нөөц бэлтгэж, хандив, нас дэвшилтийн зарлагаас нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,777,976.3 мянган төгрөг болж 143,648.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгөөр тавилга, программ хангамж, тоног төхөөрөмж, барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийг акталснаас нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнрүү бичилт хийгдээгүй, өмнөх үеийн үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээнд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 350,372.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 25,646.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 376,018.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор төсвийн захирагчийн төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 6 чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 376,018.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 402,215.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 2,991.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг шатсан барилгын материалыг хоёрдагч түүхий эд болгож борлуулсны орлого болох зөрчил гаргаад хураагдсан автомашиныг борлуулсны орлого, урсгал үйл ажиллагаанд 382,643.7 мянган төгрөгийг зарцуулж, 22,562.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 382,643.7 мянган төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 11,663.2 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,228.7 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар, байр

ашиглалттай холбоотой зардал 308.5 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 39,084.9 мянган төгрөгөөр буюу 71.2 хувиар, хангамж, бараа материалын зардал 1,844.5 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар, томилт зочины зардал 464.0 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2,433.6 мянган төгрөгөөр буюу 50.4 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 8,505.2 мянган төгрөг буюу 21.8 хувиар тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орлого дараах эх үүсвэрээс бүрдсэн байна. Үүнд:

- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зардалд 5,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас,
- Нэр бүхий 10 иргэнээс 1,384.0 мянган төгрөгийг хандив,
- Төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөрийн хөнгөлөлт 10,116.8 мянган төгрөгийг Булган мээж ХХК-иас,
- Хамтарсан багийн сургалтын зардалд 300.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-аас,
- Хагас жилийн мал тооллогын зардалд 838.0 мянган төгрөг, мэдээлэл цуглуулах судалгааны зардал 50.0 мянган төгрөгийг нийт 878.0 мянган төгрөгийг Статистикийн хэлтсээс,
- Нэр бүхий 10 өрхийн хүнсний дэмжлэгт 500.0 мянган төгрөгийг ХГБХЗХөгжлийн газраас,
- Огтоно устгалын зардалд 5,100.0 мянган төгрөгийг ХХААГ-аас,
- Өмнөх оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлага 5,365.4 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогоос,
- ногоон байгууламжийн зардалд 5,000.0 төгрөг төгрөгийг Булган аймгийн БОАЖ-ын газраас тус тус санхүүжсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 1,384.0 мянга, Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 10,116.8 мянга, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 5,000.0 мянга, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 17,153.5 мянга нийт 33,654.3 мянган төгрөгийн орлого хүлээн авч, бараа үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 11,374.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаар 17,147.6 мянган төгрөгийн нийт 28,522.4 мянган төгрөгийг зарцуулж, 333.1 мянган төгрөгийн андуурсан гүйлгээг буцааж, 4,798.8 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн авлагаар тусгаж тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн 39201, 39203, 39205, 39207 дансанд 9 нэр төрлийн 44,209.9 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн

зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн данс болон үндсэн үйл ажиллагааны зориулалтаас бусад арга хэмжээний зардлыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулахаар зарцуулалтын эрх олгоогүйгээс шалтгаалж, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнтэй зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96 мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- ✚ Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг Могод сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/168 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг шатахуун зарцуулалтыг он дамжуулан тайлагнаагүй, хавсран ажил гүйцэтгэсэн нэмэгдлийг олгоогүй, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтаар бусаар зарцуулаагүй 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн эзэмшилдээ байгаа боловч хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн шинэчлэн тогтоох, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалтын эрх нээхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Сумын ИТХ-ын хуралдаанаар төсөв батлахдаа Захирагчийн ажлын албаны орон тоог 18 байхаар баталсан нь “Сумдын засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15 байхаар байтал 3 орон тоогоор илүү цалингийн зардлыг баталж байгаад анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,078.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,478.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 600.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 9,478.8 мянган төгрөгийн алдааг тусгаж баталгаажуулав. Үүнд:

- ✚ Бараа материал, тээвэр шатахууны данс – 725.3 мянган төгрөг,
- ✚ Үндсэн хөрөнгө – 580.0 мянган төгрөг,
- ✚ Бусад бараа ажил үйлчилгээний зардал – 8,173.6 мянган төгрөг,

Энэ нь УСНББОУС 27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, “Үнэн зөв толилуулга” нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг”, НББОУС 8-ын 10.Б.1-д “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх” заалтуудтай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

4.3.1 Нормын хувцас зөвлөн эдлэлийн зардлаас 600.0 мянган төгрөгөөр ажлын хувцас бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин тавилга эд хогшил бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу 2020-2021 хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотоод хяналт шалгалтын баг томилуулан ажиллуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Могод сумын ЗДТГ	5	10,078.8	3	9,478.8	0	0	1	600.0	1	0